УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/32/НА-СТА-ТШЗ

---


Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
3. Аудитын тайлан ........ 11
  3.1 Ерөнхий зүйл ........ 11
  3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
  3.4 Материаллаг байдал ........ 12
  3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
  3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
  3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
  3.8 Аудитын гол асуудал ........ 14
  3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
  3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
  3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/32/НА-СТА-ТЦЗ
танай ______-ны № ______-т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ё.МӨНХЗУЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200366

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,703,700.00** | **1,064,800.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,703,700.00 | 1,064,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,703,700.00 | 1,064,800.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,703,700.00 | 1,064,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,859,614.38** | **14,178,414.44** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 16,859,614.38 | 14,178,414.44 |
| **392** | **Биет хөрөнгө** | 16,559,614.38 | 13,878,414.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 70,000,000.00 | 70,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -70,000,000.00 | -70,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 29,646,000.00 | 30,105,800.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16,508,663.18 | -19,847,579.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,193,550.00 | 5,893,550.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,771,272.44 | -2,273,355.79 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 300,000.00 | 300,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,820,000.00 | 1,820,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,520,000.00 | -1,520,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **19,563,314.38** | **15,243,214.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,044,972.00** | **350,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,044,972.00 | 350,000.00 |
| **413** | **Өглөг** | 1,044,972.00 | 350,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 114,972.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 930,000.00 | 350,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 930,000.00 | 350,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **18,518,342.38** | **14,893,214.44** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 18,518,342.38 | 14,893,214.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -21,369,229.43 | -24,994,357.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -21,369,229.43 | -21,369,229.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -3,625,127.94 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **19,563,314.38** | **15,243,214.44** |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **189,960,100.00** | **167,043,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,820,200.00** | **5,700,000.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,820,200.00 | 5,700,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,820,200.00 | 5,700,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,820,200.00 | 5,700,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **174,139,900.00** | **161,343,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,430,000.00** | **00.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 430,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **170,709,900.00** | **161,343,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 170,709,900.00 | 161,343,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **191,971,318.34** | **170,668,527.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **191,971,318.34** | **170,668,527.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **171,117,410.77** | **164,421,424.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **114,034,640.43** | **113,425,628.00** |
| 210101 | Үндсэн цалин | 114,034,640.43 | 113,425,628.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,009,735.00** | **14,850,724.54** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,928,470.74 | 11,144,588.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,319,184.38 | 951,088.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 653,548.28 | 687,702.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,427.09 | 187,940.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 758,104.51 | 1,879,404.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,680,000.00** | **1,260,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 1,680,000.00 | 1,260,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,773,845.60 | 17,793,599.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,120,192.60 | 4,067,835.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,867,992.00 | 9,112,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,331,761.00 | 2,423,364.26 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,453,900.00 | 2,190,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,197,500.00** | **4,200,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,197,500.00 | 4,200,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,838,600.00** | **2,651,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,838,600.00 | 2,651,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,446,700.00** | **6,198,972.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,661,200.00 | 4,820,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 96,500.00 | 96,500.00 |

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 107,000.00 | 106,472.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 470,000.00 | 830,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,136,389.74** | **4,040,999.94** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,290,000.00 | 200,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,846,389.74 | 3,840,999.94 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,853,907.57** | **6,247,103.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,850,000.00** | **3,975,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,850,000.00 | 3,975,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **15,003,907.57** | **2,271,703.50** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,003,907.57 | 2,271,703.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-2,011,218.34** | **-3,625,127.94** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **10,666.86** | **00.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,666.86 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-10,666.86** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,021,885.20** | **-3,625,127.94** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **189,960,100.00** | **167,043,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,820,200.00** | **5,700,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **15,820,200.00** | **5,700,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,820,200.00 | 5,700,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,820,200.00 | 5,700,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **174,139,900.00** | **161,343,400.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,430,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 430,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **170,709,900.00** | **161,343,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 170,709,900.00 | 161,343,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **189,960,100.00** | **167,043,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **189,960,100.00** | **167,043,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **169,106,192.43** | **160,796,296.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **113,919,668.43** | **113,540,600.00** |
| 210101 | Үндсэн цалин | 113,919,668.43 | 113,540,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,009,735.00** | **14,850,724.54** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,928,470.74 | 11,071,420.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,319,184.38 | 951,088.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 653,548.28 | 760,870.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,427.09 | 187,940.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 758,104.51 | 1,879,404.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,680,000.00** | **1,260,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 1,680,000.00 | 1,260,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,121,489.00** | **15,214,499.96** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,450,000.00 | 2,428,935.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,740,228.00 | 9,112,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,331,761.00 | 2,423,364.26 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,500,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,099,500.00 | 1,250,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,500,000.00** | **6,880,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,250,000.00 | 2,330,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 350,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,250,000.00 | 4,200,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,838,600.00** | **2,651,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,838,600.00 | 2,651,500.00 |

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,746,700.00** | **6,198,972.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,661,200.00 | 4,820,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 90,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 96,500.00 | 96,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 107,000.00 | 106,472.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 770,000.00 | 830,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,290,000.00** | **200,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,290,000.00 | 200,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,853,907.57** | **6,247,103.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,850,000.00** | **3,975,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,850,000.00 | 3,975,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **15,003,907.57** | **2,271,703.50** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,003,907.57 | 2,271,703.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **00.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **00.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **14** | **Бусад эх үүсвэр** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **00.00** | **00.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **00.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **00.00** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-19,347,344.23** | **00.00** | **20,540,227.58** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-19,347,344.23** | **00.00** | **20,540,227.58** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -2,021,885.20 | 00.00 | -2,021,885.20 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-21,369,229.43** | **00.00** | **18,518,342.38** |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-21,369,229.43** | **00.00** | **18,518,342.38** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-21,369,229.43** | **00.00** | **18,518,342.38** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -3,625,127.94 | 00.00 | -3,625,127.94 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **39,887,571.81** | **00.00** | **-24,994,357.37** | **00.00** | **14,893,214.44** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 176,343,400.00 | **167,043,400.00** | 9,300,000.00 | 0.00 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 176,343,400.00 | 167,043,400.00 | 9,300,000.00 | 0.00 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 172,368,000.00 | 160,796,296.5 | **11,571,703.50** | 0.00 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 113,540,600.00 | 113,540,600.00 | 0.00 | 100.0% |
| Үндсэн цалин | 113,540,600.00 | 113,540,600.00 | 0.00 | 100.0% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **15,586,100.00** | **14.850,724.54** | **753,375.46** | 95,3% |
| Тэтгэврийн даатгал | 10,968,000.00 | 11,071,420.63 | (103,420.63) | 100.9% |
| Тэтгэмжийн даатгал | 1,154,500.00 | 951,088.59 | 203,411.41 | 82.4% |
| ҮОМШӨ-ний даатгал | 923,600.00 | 760,870.81 | 162,729.19 | 82.4% |
| Ажилгүйдлийн даатгал | 230,900.00 | 187,940.47 | 42.959.53 | 81.4% |
| Эрүүл мэндийн даатгал | 2,309,100.00 | 1,879,404.04 | 429.695.96 | 81.4% |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,260,000.00** | **1,260,000.00** | 0.00 | 100.0% |
| Байрны түрээс | 1,260,000.00 | 1,260,000.00 | | 100.0% |
| **Хангамж, бараа материалын зардал** | **15,214,500.00** | **15,214,499.96** | **0,04** | **100.0%** |
| Бичиг хэрэг | 2,171,200.00 | 2,428,935.7 | (257,735.70) | 111.0% |
| Тээвэр, шатахуун | 9,112,200.00 | 9,112,200.00 | | 100.0% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,681,100.00 | 2,423,364.26 | 257,735.74 | 90.4% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,250,000.00 | 1,250,000.00 | | 100.0% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,880,000.00** | **6,880,000.00** | 0.00 | 100.0% |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,330,000.00 | 2,330,000.00 | 0.00 | 100.0% |
| Урсгал засвар | 4,200,000.00 | 4,200,000.00 | 0.00 | 100.0% |
| Тавилга | 350,000.00 | 350,000.00 | 0.00 | 100.0% |
| **Томилолт, зочны зардал** | **3,318,000.00** | **2,651,500.00** | **666,500.00** | 79.9% |
| Дотоод албан томилолт | 3,318,000.00 | 2,651,500.00 | 666,500.00 | 79.9% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,205,500.00** | **6,198,972.00** | **6,528.00** | 99.9% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,820,000.00 | 4,820,000.00 | 0.00 | 100.0% |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 | 0.00 | 100.0% |
| Даатгалын үйлчилгээ | 96,500.00 | 96,500.00 | 0.00 | 100.0% |
| Тээврийн хэрэгслийн татвар | 113,000.00 | 106,472.00 | 6,528.00 | 99.9% |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 | 0.00 | 100.0% |
| Мэдээлэл технологийн зардал | 830,000.00 | 830,000.00 | 0.00 | 100.0% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **363,300.00** | **200,000.00** | **163,300.00** | **55.1%** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | **10,000,000.00** | | **10,000,000.0** | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хичээл үйлдвэрийн дадлага хийх | 363,300.00 | 200,000.00 | 163,300.00 | 55.1% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,975,400.00 | **6,247,103.50** | **(2,271,703.5)** | 157.1% |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 3,975,400.00 | 3,975,400.00 | 0.00 | 100.0% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,975,400.00 | 3,975,400.00 | 0.00 | 100.0% |
| ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ ШИЛЖҮҮЛЛЭГ | 0.00 | **2,271,703.5** | **(2,271,703.5)** | 0.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,төвлөрүүлэх шилжүүллэг | 0.00 | **2,271,703.5** | **(2,271,703.5)** | 0.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 176,343,400.00 | **164,771,696.50** | **11,571,703.50** | 99.1% |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 161,343,400.00 | **159,071,696.50** | **2,271,703.5** | 0.00 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 15,000,000.00 | **5,700,000.00** | **9,300,000.00** | 114.0% |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,000,000.00 | 5,700,000.00 | 930,000,000.00 | 114.0% |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 0.00 | 0.00 | 0.00 | |
| **Байгууллагын тоо** | **1.00** | **1.00** | 0.00 | **100.0%** |
| **Ажиллагсдын тоо** | **10.00** | **10.00** | 0.00 | **100.0%** |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 6.00 | 6.00 | 0.00 | 100.0% |
| Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | 0.00 | 100.0% |
| | | | | |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн өмчийн захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрөөр хэрэгжих бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, орон нутгийн өмч хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах, дуудлага худалдааг зохион байгуулах, орлогыг төвлөрүүлэх, орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгийг актлах, худалдах, балансаас балансад шилжүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлүүлэх, жилийн эцсийн санхүүгийн болон хөрөнгийн тайлан мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулж хүргүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 195.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 170,668.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 1,706.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 1,365.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,320.1 мянган төгрөгөөр буюу 28.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.
*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 2,703.7 | 1,064.8 | -1,638.9 |
| Үндсэн хөрөнгө | 16,859.6 | 14,178.4 | -2,681.2 |
| **Нийт хөрөнгө** | 19,563.3 | 15,243.2 | -4,320.1 |
| Өр төлбөр | 1,044.9 | 350.0 | -694.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 18,518.3 | 14,893.2 | -3,625.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 19,563.3 | 15,243.2 | -4,320.1 |

Бараа материалын дансны үлдэгдэл 1,064.8 мянган төгрөг болж 1,638.9 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,178.4 мянган төгрөг болж 2,681.2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 1,159.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Өр төлбөр дансны үлдэгдэл 350.0 мянган төгрөг болж 694.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагад төлөх өглөг барагдуулж, шинээр өглөг үүсжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,893.2 мянган төгрөг болж 3,625.1 мянган төгрөгөөр буурсан нь нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 22,916.7 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 21,302.8 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 203,630.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 203,630.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27,287.4 мянган төгрөгөөр бууруулж 176,343.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант 2021 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 176,343.0 мянган төгрөгийн төсөв батласнаас 171,343.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 161,343.4 мянга, 5,700.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 167,043.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 159,071.6 мянган төгрөгийг зарцуулж 2,271.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 159,071.6 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байна.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Орон нутгийн өмчийн газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар албан шаардлага өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 131, хугацаа хоцроосон 18, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэл байршуулаагүй алдаа зөрчилд зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 90 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бичиг хэргийн зардлыг анхаарах.

## 4. Аудитын илрүүлэлт

Орон нутгийн өмчийн газар нь амралтын цалинг 713.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орон нутгийн өмчийн газар | 1 | 713.2 | | | 1 | 713.2 | | | | |
| | | | | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **713.2** | | | **1** | **713.2** | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 21-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ